



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын 2018 оны санхүүгийн
тайлангийн аудит

Аудитын код: БНА-2019/1/СТА-ТӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор 2019 он

Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Цэцэгмаа

Утас: 88089024 Цахим хаяг: tsetsegmaadam@audit.gov.mn

Аудитор: П.Мөнх-Эрдэнэ

Утас: 88045601 Цахим хаяг: munkherdenep@audit.gov.mn

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	3
2	Аудитын тайлан	5
	2.1. Оршил	5
	2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
	2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
	2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
	2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
	2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	8
	2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	8
	2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
	2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
	2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	9
	2.11. Шилэн дансны мэдээлэл.....	9
	2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
	2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	11
	3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	11
	3.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан	12
	3.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	13
	3.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	14

1 Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Номгон, Баянхонгор сум
Утас, факс 70-44-25-84
E-mail: bayankhongor@audit.gov.mn

2019. 03. 15 № 2/143
танай _____-ны № _____-т

Г Аудитын гэрчилгээ Г

Г БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ НИСЭХ
БУУДЛЫН ДАРГА Н.БАЯРХҮҮ ТАНАА Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

2519267

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Баянхонгор аймаг дахь Нисэх буудал нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг дарга Н.Баярхүүд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС/УСНББОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.03.12-наас 2019.03.15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.03.15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад

хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын аудитор П.Мөнх-Эрдэнэ хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймаг дахь Нисэх буудал 2018 оны санхүүгийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2019.02.13-ны өдрийн 03 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС,НББОУС, УСНББОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Баянхонгор аймаг дахь Нисэх буудал талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Баянхонгор аймаг дахь Нисэх буудал нь “Нисэхийн аюулгүй байдлыг найдвартай ханган, агаарын тээврийн ая тух, түргэн шуурхай үйлчилгээг бий болгож, зорчигчдод соёлч боловсон үйлчлэх” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын удирдлага Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Иргэний нисэхийн тухай хууль
- Иргэний нисэхийн дүрэм

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн.

Баянхонгор аймаг дахь Нисэх буудал санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Veritech erp” программ хангамж ашигладаг байна.

Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 6 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 6 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн борлуулалтын өртгийг сонгов.

Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын 2018 оны борлуулалтын өртөг 815844.2 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 8158,4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 6 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 6 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэн. Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Тайлант онд нийт 3 ажилтанд шүүхийн шийдвэрээр 7,4 сая төгрөгийг Баянхонгор Нисэх буудлын Төрийн банкны харилцах данснаас аймгийн ШШГГ нь битүүмж үүсгэж шилжүүлэн ажилгүй байсан хугацааны цалин хөлсийг дээрх 3-н ажилтанд олгосон байна. Иймд төрийн албан хаагчийн буруутай үйл ажиллагаанаас төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх үйл ажиллагааны хэрэгжилт хангалтгүй байгааг дараагийн аудитаар авч үзэх шаардлагатай байна.

2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын батлагдсан төлөвлөгөөгөөр нийт урсгал зардалд 694,3 сая төгрөг зарцуулахаар батлагдсан ба тайлант хугацаанд 670,2 сая төгрөг зарцуулж, 96,5 хувийн гүйцэтгэлтэй байна.

Буулт, хөөрөлт болон бусад орлогоор 4,9 сая төгрөг оруулахаар төлөвлөгдсөн ба тайлант онд 5,4 сая төгрөг орж, өөрийн орлогын гүйцэтгэл 110,2 хувьтай байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Баянхонгор аймаг дахь Нисэх буудал Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлсэн байна.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын 2018 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Баянхонгор аймаг дахь Нисэх буудал 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу

материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

3 Аудит хийсэн санхүүгийн тайлан

3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ	0	0
1.1	Эргэлтийн хөрөнгө	0	0
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	11,238,869.16	712,439.27
1.1.2	Дансны авлага	0	1,387,155.10
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	6,600.00	0
1.1.4	Бусад авлага	258,330.00	5,310,929.12
1.1.6	Бараа материал	59,619,401.98	102,243,484.62
	Эргэлтийн хөрөнгийн дүн	71,123,201.14	109,654,008.11
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	0	0
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,156,010,017.86	2,235,708,916.98
1.2.2	Биет бус хөрөнгө	15,812,500.00	0
1.2.3	Дуусаагүй барилга	0	0
1.2.4	Биологийн хөрөнгө	0	0
1.2.5	Урт хугацаат хөрөнгө оруулалт	0	0
1.2.6	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	0	0
1.2.7	Хойшлогдсон татварын хөрөнгө	0	0
1.2.8	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	0	0
1.2.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	0	0
1.2.10	Хуримтлагдсан элэгдэл	0	0
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,171,822,517.86	2,235,708,916.98
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,242,945,719.00	2,345,362,925.09
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ	0	0
2.1.	Өр төлбөр	0	0
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	0	0
2.1.1.3	Татварын өр	302,230.00	221,885.10
2.1.1.4	НДШ - ийн өглөг	0	0
2.1.1.5	Богино хугацаат зээл	0	0
2.1.1.6	Хүүний өглөг	0	0
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	0	0
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	0	0
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/	0	0
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	10,000.00	1,259,000.00
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) - нд хамаарах өр төлбөр	0	0
2.1.1.12	Системийн өглөг	0	0
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	312,230.00	1,480,885.10
2.2	Өр төлбөрийн нийт дүн	312,230.00	1,480,885.10
2.3	Эздийн өмч	0	1,519,736,486.75
2.3.1	Өмч: - төрийн	0	1,030,960,000.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	0	488,776,486.75
2.3.9	Хуримтлагдсан ашиг	1,242,633,489.00	824,145,553.24
	Эздийн өмчийн дүн	1,242,633,489.00	2,343,882,039.99
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,242,945,719.00	2,345,362,925.09

3.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

Мөр	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1.1	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО	0	0
1.1.1	Борлуулалтын орлого	33,029,820.35	12,236,316.72
	Буулт хөөрөлтийн орлого	609,641.44	1,637,790.00
	Газрын техник үйлчилгээний орлого	2,566,912.07	3,440,789.00
	Шатахуун тээвэрлэлтийн орлого	29,853,266.84	6,237,757.01
	Үйл ажиллагааны бусад орлого	0	919,980.71
	БОРУУЛАЛТЫН ОРЛОГЫН ДҮН	33,029,820.35	12,236,316.72
1.2	БОРЛУУЛАЛТЫН ӨРТӨГ	764,936,470.88	815,844,282.97
	Түүхий эд материалын зардал	48,759,201.00	0
	Бичиг хэрэг	4,576,563.54	5,039,426.88
	Албан конторын зардал	458,500.00	847,260.00
	Шатахуун	45,291,337.09	46,947,342.41
	Үндсэн цалин	162,632,444.45	215,273,680.47
	Илүү цаг	13,177,294.80	17,293,170.08
	Амралтын мөнгө	26,632,886.60	32,830,338.63
	Цалингийн бусад нэмэгдэл	95,801,555.96	95,498,518.91
	Үндсэн ба нэмэгдэл цалингийн нийт дүн	298,244,181.81	360,895,708.09
	Хоолны үнийн хөнгөлөлт	51,093,002.00	54,980,000.00
	Нийгмийн даатгалын зардал (Үйлдвэрлэл)	41,707,606.72	53,225,598.48
	Сэлбэг засвар-Барилга	7,238,419.68	7,483,959.72
	Сэлбэг засвар-Автомашин	6,591,333.43	8,316,741.02
	Сэлбэг засвар-Аэродром	10,157,242.56	10,235,517.81
	Сэлбэг засвар -ТТ	11,262,109.23	18,672,244.11
	Сэлбэг засвар	35,249,104.90	44,708,462.66
	Цахилгаан	21,988,525.02	23,303,910.55
	Дулаан	16,110,245.50	16,067,370.42
	Холбооны зардал	4,437,178.59	5,874,087.73
	Ашиглалтын зардлын дүн	42,535,949.11	45,245,368.70
	Үндсэн хөрөнгийн элэгдэл	138,164,410.68	135,139,231.13
	Биет бус хөрөнгийн хорогдуулга	17,250,000.00	15,812,500.00
	Элэгдлийн зардлын дүн	155,414,410.68	150,951,731.13
	Үл хөдлөх хөрөнгийн татвар	16,576,100.00	16,370,100.00
	Газрын татвар	618,000.00	824,000.00
	Тээврийн хэрэгслийн татвар	426,800.00	385,800.00
	Хөрөнгийн даатгал	4,360,859.00	3,886,448.00
	Татвар, даатгалын зардлын дүн	21,981,759.00	21,466,348.00
	Хөдөлмөр хамгаалал	2,088,831.22	17,162,450.00
	Дотоод сургалтын зардал	650,000.00	1,000,000.00
	Сургалтын зардлын дүн	650,000.00	1,000,000.00
	Дотоод томилолт	11,808,932.56	9,554,380.00
	Албан томилолтын зардлын дүн	11,808,932.56	9,554,380.00
	Харуул хамгаалалт	247,500.00	149,063.88
	Цэвэрлэгээний зардал	2,216,891.25	2,289,642.69
	Гал команд	1,945,500.00	1,081,500.00
	Үйлдвэрлэлийн бусад зардал	667,200.00	300,000.05
1.3	НИЙТ АШИГ (АЛДАГДАЛ)	-731,906,650.53	-803,607,966.25
1.4	ҮЙЛ АЖИЛЛАГАА (БОРЛУУЛАЛТ, ЕРӨНХИЙ УДИРДЛАГА)-НЫ ЗАРДАЛ	41,257,681.63	1,800,000.00
	Бичиг хэргийн зардал	45,200.00	0
	Үндсэн цалин	23,845,595.91	0
	Амралтын хөлс	1,477,696.00	0
	Цалингийн бусад нэмэгдэл	10,336,480.24	0
	Нийт Үндсэн болон нэмэгдэл цалин	35,659,772.15	0
	Нийгмийн даатгалын шимтгэл	4,424,709.48	0
	Засвар үйлчилгээний зардал	916,000.00	0
	Шуудан холбооны зардал	34,500.00	0

Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

	Ашиглалтын зардлын дүн	34,500.00	0
	Дотоод томилолт	177,500.00	0
	Албан томилолтын зардлын дүн	177,500.00	0
	Аудит баталгаажуулалтын зардал	0	1,800,000.00
1.5	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ (АЛДАГДАЛ)	-773,164,332.16	-805,407,966.25
2	ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ (АЛДАГДАЛ)	665,939,660.11	386,920,030.49
2.6.1	Бусад үйл ажиллагааны бус орлого	671,963,821.11	778,868,750.80
	Хүүгийн орлого	936,772.27	1,613,844.82
	Бусад үйл ажиллагааны бус орлого	2.08	5,191,064.33
	Санхүүжилт орлого	611,868,521.00	651,157,711.47
	Систем хоорондын тооцоогоорх орлого	49,600,033.01	117,967,471.03
	ҮХ-н дотоод хөдлөлийн борлуултын олз	9,558,492.75	2,938,659.15
2.6.2	Бусад үйл ажиллагааны бус зардал	6,024,161.00	391,948,720.30
	Шагнал	0	50,000.00
	Тэтгэмж	1,733,661.00	1,530,000.00
	Түлшний хөнгөлөлт	1,200,000.00	1,400,000.00
	Банкны үйлчилгээний зардал	105,500.00	134,399.90
	Спорт арга хэмжээний зардал	0	485,000.00
	Баяр ёслолын зардал	2,985,000.00	0
	Үйл ажиллагааны бус бусад зардал	0	4.33
	Систем хоорондын тооцоогоорх зардал	0	56,660,073.22
	ҮХ-н дотоод хөдлөлийн борлуултын гарз	0	2,938,659.15
	ҮХ данснаас хассаны гарз	0	328,750,583.70
	ҮХ данснаас хассаны олз, гарзын зөрүү	0	-328,750,583.70
2.3	ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ (АЛДАГДАЛ)-ЫН ДҮН	665,939,660.11	386,920,030.49
3	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-107,224,672.05	-418,487,935.76
4	Татварын дараах ашиг (алдагдал)	-107,224,672.05	-418,487,935.76
5	Ердийн ажиллагааны ашиг (алдагдал)	-107,224,672.05	-418,487,935.76
6	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-107,224,672.05	-418,487,935.76

3.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

Д/д	Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	0	0	0
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0	0	0
3	Залруулсан үлдэгдэл	0	0	0
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0	0	0
5	Бусад дэлгэрэнгүй орлого	0	0	0
6	Өмчид гаргасан өөрчлөлт	0	0	0
7	Зарласан ногдол ашиг	0	0	0
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0	0	0
9	2017 оны 12 - р сарын 31-ний үлдэгдэл	0	1,242,633,489.00	1,242,633,489.00
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0	0	0
11	Залруулсан үлдэгдэл	0	1,242,633,489.00	1,242,633,489.00
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0	-418,487,935.76	-418,487,935.76
13	Бусад дэлгэрэнгүй орлого	0	0	0
14	Өмчид гаргасан өөрчлөлт	0	0	0
15	Зарласан ногдол ашиг	0	0	0
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0	0	0

17	2018 оны 12 - р сарын 31-ний үлдэгдэл	1,519,736,486.75	824,145,553.24	2,343,882,039.99
----	---------------------------------------	------------------	----------------	------------------

3.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

Д/д	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0	0
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	621,499,879.59	675,829,614.43
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	6,880,444.32	435,807.90
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	170,831.00	1,589,868.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	611,868,521.00	661,950,000.00
1.1.6	ҮҮА-ны бусад мөнгөн орлого	2,580,083.27	11,853,938.53
1.1.6.1	Банк хоорондын гүйлгээ	6,690,220.00	2,370,000.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	611,377,883.37	686,762,052.34
1.2.1	Ажиллагчдад төлсөн	326,911,347.57	363,679,836.52
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	84,091,042.94	76,383,613.23
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	35,303,948.00	94,074,220.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	43,646,737.00	41,831,490.63
1.2.6	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	60,558,385.00	17,321,060.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	51,297,802.86	54,210,478.85
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	4,360,859.00	18,137,034.11
1.2.9	ҮҮА-ны бусад мөнгөн зарлага	5,207,761.00	21,124,319.00
1.2.9.1	Банк хоорондын гүйлгээ	6,690,220.00	2,370,000.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	10,121,996.22	-10,932,437.91
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	936,772.27	406,008.02
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	936,772.27	406,008.02
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	936,772.27	406,008.02
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0	0
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	0	0
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	0	0
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0	0
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	11,058,768.49	-10,526,429.89
4	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	0	-10,526,429.89
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	11,238,869.16
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	712,439.27